



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (319)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Гавьяат цол хүртээж, одон медалиар шагнасан тухай*
- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Журам, бүрэлдэхүүн батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны есдүгээр сарын 15

№ 34 (319)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

507.	Пэрэнлэйн Шард Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай	Дугаар 144	821
508.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 154	822
509.	Карма Топденийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 158	822
510.	Нямын Бавуужавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 161	822
511.	Дэжидийн Хэнмэдэхэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 162	823
512.	Гомбожавын Гонгоржавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 163	823
513.	Цэдэндоржийн Дашдондовт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 164	823
514.	Пүрэвийн Жигжидсүрэнд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 165	823

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

515.	Журам, бүрэлдэхүүн батлах тухай	Дугаар 177	824
------	---------------------------------	------------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Пэрэнлэйн Шард Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай

Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, мал сүргээ өсгөх, ашиг шимийг бүрэн ашиглах, иргэдийг малжуулах, мал маллагааны арга туршилгаа залуу малчдад өвлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Завхан аймгийн Яруу сумын Хэц-Улаан багийн

малчин Дэрэнлэйн Шард Монгол Улсын гавьяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Таукейн Султаныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри

Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар

Лувсандагвын Энхтайваныг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри

Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Карма Топденийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан

Карма Топденийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Нямын Бавуужавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил идэвх санаачилгатай багшилж, дүрслэх урлагийн хичээлийг бүтээлч, үр дүнтэй арга хэлбэрээр зааж, сургуулийн тохижилт, сургалтын орчинг сайжруулах, сурагчдын авъяас, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлж, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 10

жилийн 2 дугаар дунд сургуулийн дүрслэх урлагийн багш Нямын Бавуужавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Дэжидийн Хэнмэдэхэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, шинэ бүтээл оновчтой санал гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, залуу ажилчдыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4"

ТӨХК-ийн цахилгаан засварын монтерч Дэжидийн Хэнмэдэхэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Гомбожавын Гонгоржавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл, шинжлэх ухаан, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрдэм шинжилгээний болон танин мэдэхүйн олон нийтлэл, ном туурвин, хүүхэд залуучуудад өөрийн орны түүх, соёл, уламжлал, ёс заншлыг өвлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Гомбожавын

Гонгоржавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Цэдэндоржийн Дашдондовт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл, мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, чөлөөт хэвлэлийг хөгжүүлж, ардчилал шинэчлэлд түүний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, залуу сэтгүүлчдийг дадлагажуулан сургах, монголын сэтгүүл зүйг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

сэтгүүлч Цэдэндоржийн Дашдондовт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

Пүрэвийн Жигжидсүрэнд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, тив, олон улсын болон Монгол Улсын шатрын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцон, өндөр зэрэг, цолтой тамирчид бэлтгэх, шатрын спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Пүрэвийн Жигжидсүрэнд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Журам, бүрэлдэхүүн батлах тухай

Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон оролцуулах тухай асуудлыг зохицуулах зөвлөлийн ажллах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус хуулийн 4.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын тус баталсугай.

Засгийн газраас ТОГТООХ нь:

"Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр, "Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН

САЙД

Ж.ГУРРАГЧАА

Засгийн газрын 2003 оны 177 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦЭРЭГ, ЦАГДААГИЙН БАГИЙГ НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД БЭЛТГЭХ, ОРОЛЦУУЛАХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга	-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга;
Гишүүд:	-Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга;
	-Эрүүл мэндийн яамны Бодлого, зохицуулалтын газрын дарга;
	-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

-Зэвсэгт хүчний Жанжин штабын Энхийг сахиулах газрын дарга;

-Тагнуулын ерөнхий газрын Дүн шинжилгээ, мэдээлэл, судалгааны төвийн дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга.

Нарийн бичгийн дарга

-Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн.

Засгийн газрын 2003 оны 177 дугаар тогтоолын 2 дугаар хаесралт

**ЦЭРЭГ, ЦАГДААГИЙН БАГИЙГ НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ
БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД БЭЛТГЭХ,
ОРОЛЦУУЛАХ ТУХАЙ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.2. Энхийг сахиулах болон олон

1.1. Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын улсын бусад ажиллагаанд цэрэг, цагдаагийн энхийг сахиулах болон олон улсын бусад баг оролцуулах тухай НҮБ, олон улсын ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг холбогдох байгууллага, аливаа улсын зүгээс зохицуулах үүрэг бүхий зөвлөл (цаашид хүсэлт тавьсан тохиолдолд Засгийн газраас "зохицуулах зөвлөл" гэх)-ийн удирдлага, зохицуулах зөвлөлийг байгуулж болно. зохион байгуулалт, эрх, үүргийг энэхүү 1.3. Зохицуулах зөвлөл нь дараахь журмаар зохицуулна. чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна:



1.3.1. цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын зөвлөлийн дарга болон түүний орлогчийн энхийг сахиулах болон олон улсын бусад санал болгосноор шаардлагатай үед зохион ажиллагаанд оролцуулах тухай Засгийн байгуулан хуралдуулна.

газрын шийдвэр гаргуулахад дэмжлэг үзүүлэх;

Зохицуулах зөвлөлийн хурлыг зөвлөлийн нийт гишүүдийн гуравны хоёр нь

1.3.2. Засгийн газрын шийдвэр гарсны дараа цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэж оролцуулах ажиллагааг зохицуулах.

оролцсоноор хүчинтэйд тооцно.

1.4. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох тухайн цэрэг, цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийн онцлогоос хамаарч зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн өөр өөр байж болно.

2.3. Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын талаархи материалуудыг нарийн бичгийн дарга бэлтгэн хуралдаан эхлэхээс 2 хоногийн өмнө гишүүдэд тараах бөгөөд аливаа асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Гурав. Зохицуулах зөвлөлийн эрх, үүрэг

Хоёр. Зохицуулах зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, хурал

2.1. Зохицуулах зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд түүний бүрэлдэхүүн нь төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн байна.

3.1. Зохицуулах зөвлөл нь дараахь эрхийг эдэлнэ:

3.1.1. зохицуулах зөвлөл нь НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох цэрэг, цагдаагийн багийн зардал, төсөв хөрөнгийн талаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.2. Зохицуулах зөвлөлийн хурлыг



3.1.2. НҮБ-ын энхийг сахиулах болон цагдаагийн баг оролцуулах хууль зүйн олон улсын бусад ажиллагаанд оролцох үндэслэлийг судалж, санал боловсруулах; цэрэг, цагдаагийн багийн бүрэлдэхүүний

бэлтгэлийг хангахтай холбогдсон асуудлаар 3.2.2. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд цэрэг, цагдаагийн баг оролцуулах асуудлаар олон улсын холбогдох бусад байгууллага, бусад

3.1.3. ажлын явц, байдал болон улс оронтой гэрээ, хэлэлцээ байгуулахад тулгамдаж буй асуудлуудыг Зэвсэгт хүчний дэмжлэг үзүүлэх;

Ерөнхий командлагч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд 3.2.3. цэрэг, цагдаагийн багийн бэлтгэлийн түвшин, зэвсэглэл техникийн хангалт, бусад боломжийг үнэлэх;

тус тус танилцуулж, энэ талаар мэдээлэл өгөх, баг илгээх тухай шийдвэр гаргахтай холбогдуулж бусад байгууллагаас мэдээлэл шаардаж авах.

3.2. Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын оролцуулах тухай Засгийн газрын шийдвэр эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд дэмжлэг үзүүлэх;

ажиллагааг зохицуулах чиглэлээр 3.2.5. олон улсын бусад ажиллагаанд зохицуулах зөвлөл нь дор дурдсан үүрэг оролцуулах тухай асуудлыг Засгийн газраас Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.1. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд цэрэг, 3.2.6. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох



цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүний агсамж, боловсруулах;

хангалтын байдал олон улсын жишигт нийцэж

байгаа эсэх талаар мэргэжлийн дүгнэлт

гаргах.

3.3. Засгийн газрын шийдвэр гарсны дараа цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэж оролцуулах ажиллагааг зохицуулах чиглэлээр зохицуулах зөвлөл нь дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:

3.3.1. бие бүрэлдэхүүнийг олон улсын ажиллагаанд оролцуулахтай холбогдсон асуудал (агсамж, хангалт, хил, гаалиар нэвтрүүлэх гэх мэт)-аар холбогдох төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.3.2. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны нөхөн төлбөрөөс энхийг сахиулагчид олгох төлбөрийн хэмжээний талаар санал

3.3.3. цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх болон оролцуулах үеийн бие бүрэлдэхүүний агсамж, хангалттай холбогдсон асуудлуудыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.4. бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэлжилтийн байдал, гүйцэтгэх ажлын удирдамжийг хянах, олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар бие бүрэлдэхүүнд зааварчилга, үүрэг, чиглэл өгөх;

3.3.5. зохицуулах зөвлөл нь цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэж оролцуулахтай холбогдсон асуудлаар төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1